

ГОВЬСУМБЭР АЙМАГ
НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар A/18

Чойр

Төрийн албан хаагчийн
нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 60, 61 дүгээр зүйл, Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

- Нийтийн Номын сангийн “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Хөтөлбөрийн хүрээнд жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг зохион байгуулахыг Сан хөмрөгч, хүний нөөцийн ажилтан /М.Аюушжав/-д, шаардагдах хөрөнгийг жил бүр тусган төсөвт тусган санхүүжүүлж байхыг Нягтлан бодогч /Ц.Цогзолмаа/ нарт үүрэг болгосугай.



Нийтийн Номын Сангийн захирлын
2021 оны 09 сарын 30 өдрийн
18 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Нийтийн Номын Сангийн албан хаагчдын ажлыг бодитойгоор дүгнэх, хамт олонч төлөвлүүлийг бүрдүүлэх, албанад хандах хандлага, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

2.1. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

2.1.1 Албан хаагчдын үйл ажиллагааг үнэн зөв, бодитойгоор үнэлэх, шагнаж урамшуулах

2.1.2 Албан хаагчдын амьдрах нөхцөл, ахуй хангамжийг сайжруулах бололцоог бүрдүүлэх

2.1.3 Ажлын байрны сэтгэл ханамжийг дээшлүүлэх

3.1.4 Албан хаагчдын сурх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, идэмжлэг үзүүлэх

3.1.5 Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх

3.1.6 Хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх

3.1.7 Ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлэх

2.2. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь энэхүү хөтөлбөрийн салшгүй хэсэг бөгөөд төлөвлөгөөг жил бүр дүгнэнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана.

3.1.1. Төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд ажиллах

3.1.2 Хүртээмжтэй оролцоог хангасан байх

3.1.3 Ил тод нээлттэй байдлыг хангах

3.1.4 Бодитой үр дүнтэй байх

3.1.5 Нөөц бололцоог бүрэн дайчлах

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Албан хаагчид хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, ажлын үзүүлэлт, хөдөлмөрийн бүтээмжид нь ахиуц, өөрчлөлт гарна.

4.1.2 Төрийн албан тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар бүрэн хангагдана.

4.1.3. Албан хаагчийн амьдрал ахуй, орон байрны нөхцөл сайжирна.

4.1.4. Албан хаагчдын ажилдаа хандах хандлага өөрчлөгдөж, тогтвортсуурьшилттай ажиллах нөхцөл бүрдэнэ.